

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА

О.ГАНЦООЖ

**БЭЛЧЭЭР УСЖУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ  
ХУДАГ ГАРГАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Бэлчээр усжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй худаг гаргах**

Төслийн дугаар: **ХОАДАСЗДТГ/202002011**

**2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.08.13

**Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Бэлчээр усжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Тендериин баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн цагаар 10 цаг 30 минут, Улаанбаатарын цагаар 11 цаг 30 минутаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн орон нутгийн цагаар 11 цаг 00 минут, Улаанбаатарын цагаар 12 цаг 00 минутаас** нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх.  
**тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендериин баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймаг Дарви сум  
Засаг даргын Тамгын газар,  
2 давхар 204 тоот  
Утас: 86080606, 99765626  
вэб:[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>      | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b> | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p>   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>             | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <p class="list-item-l1">(а) Үнийн санал;</p> <p class="list-item-l1">(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;</p> <p class="list-item-l1">(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p class="list-item-l1">(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p class="list-item-l1">(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p>   |
| <b>4. Тендерийн үнэ</b>                   | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.</p> <p>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 5 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.</p> |
| <b>5. Үнийн саналын</b>                   | <p>5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>  |

**хүчинтэй  
байх  
хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө уtsan холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт 2019 он</b></li> <li>2. <b>Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт, өмнө үйлчлүүлэгчийн тодорхойлолт/;</b></li> <li>3. <b>Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар</b></li> <li>4. <b>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар, хавсралт болон гэрээний хамт Тендерт оролцогч БОАЖ-ын сайдын 2013 оны А/307 тушаалаар батлагдсан дараах тусгай зөвшөөрөл ирүүлнэ.</b> <ol style="list-style-type: none"> <li>4.1. Цооног өрөмдөх, тоноогох, сэргээн засварлах.</li> <li>4.2. Усны хайгууль судалгаа явуулах. Хэрэв тендерт оролцогч усны хайгууль судалгаа явуулах тусгай зөвшөөрөлгүй бол ийм зөвшөөрөлтэй компанийтай усны хайгууль хийх гэрээ байгуулсан байх шаардлагатай</li> </ol> </li> <li>5. <b>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ тендер зарласнаас хойш тендер хүлээн авах хүртэлх хугацаанд авсан байх</b></li> <li>6. <b>Харилцагч банкины өргүй болохыг тодорхойлсон тодорхойлолт</b></li> <li>7. <b>Нийгмийн даатгалын тодорхойлолт /2019 он, 2020 оны эхний улирлын нийгмийн даатгал төлсөн тооцооны хуудас/ Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх</b></li> <li>8. <b>Татварын газрын тодорхойлолт – татварын цахим системээс авсан бар код бүхий тодорхойлолт /тендер зарласнаас хойш тендер хүлээн авах хүртэлх хугацаанд авсан байна. Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх.</b></li> <li>9. <b>Оролцогч компаний танилцуулга</b></li> <li>10. <b>Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</b></li> <li>11. <b>Тендерт оролцогчийн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл</b></li> <li>12. <b>Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкуудаас тодорхойлолт, лавлагаа авахад татгалзах зүйлгүй талаархи мэдэгдэл ирүүлэх</b></li> <li>13. <b>Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч буй эсэх тухай мэдэгдэл</b></li> <li>14. <b>Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар</b></li> <li>15. <b>ТШӨХ-д заасан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</b></li> </ol>

	<p><b>16. Машин механизмын гэрчилгээ, тоног төхөөрөмжийн техникийн паспорт</b></p> <p><b>17. Ажлын төсөөв</b></p> <p><b>18. Ажлын төсөөвт ажлын төсвийн үнэ 100000 /нэг сая/ төгрөг тусгана.</b></p> <p><b>Бусад нэмэлт шаардлагууд</b></p> <p>1. Тендерт оролцогч нь Техникийн тодорхойлолтонд заасан ажлын нэр болон тоо хэмжээг төсөөвт дутуу тооцсон тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>2. Тендерт оролцогч нь уг ажлыг санал болгосон үнийн саналд багтаан тухайн ажлыг дуусгаж хүлээлгэн өгөх баталгааг гарган ирүүлнэ.</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>1. <b>Өрөмдлөгийн суурь машин</b></li> <li>2. <b>Компрессор</b></li> <li>3. <b>Өрөмдлөгийн штанг /метрээр/</b></li> <li>4. <b>Үзүүрийн багаж</b></li> <li>5. <b>Ус шавхалтын төхөөрөмж</b></li> <li>6. <b>Шүүрийн яндан, шүүр</b></li> <li>7. <b>Тээврийн болон тусгай зориулалтын машин</b></li> </ul>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> Давхар болон өрөөний дугаар: Огноо: <b>2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр</b> Цаг: <b>Орон нутгийн цагаар 10 цаг 30 минут</b> <b>Улаанбаатарын цагаар 11 цаг 30 минут</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Ховд аймгийн Дарви сумын Засаг даргын Тамгын газар</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Ховд аймгийн Дарви сумын ЗДТГ-ын 2 давхар 202 тоот өрөөнд</b> Огноо: <b>2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр</b> Цаг: <b>Орон нутгийн цагаар 11 цаг 00 минут</b> <b>Улаанбаатарын цагаар 12 цаг 00 минут</b></p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Хөвд аймгийн **Дарви** суманд бэлчээр усжуулалтанд зориулсан инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна.

### **2. Ажлын тодорхойлолт**

2.1. Худгийг сэргээн засварлах, шинээр барихаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч, худгийн солбилцлыг нарийвчлан тодорхойлсон байна.

2.2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгох, худгийн барилга барих ажлыг гүйцэтгэнэ.

2.3. Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө. Үүнд:

- Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгэгч суурилуулах, худгийн барилга, усан сан, халаах зуух, мал услах онгоц, талбай зэргийг барьж байгуулах ажлыг багтаана.
- Өрөмдмөл худгийн барилгыг дотор **1,5 м<sup>3</sup>**- ээс доошгүй багтаамжтай усан сан барьж байгуулна.
- Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах тухай” Ховд аймаг, нийслэлийн ажлын хэсгийн акт №1-ийн дагуу сэргээн засварлах, шинээр гаргах ажлын төрөл хэмжээ өртгийг тогтооно.
- Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлаж, шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай ”Ховд аймаг, нийслэлийн ажлын хэсгийн акт №2-ыг үйлдэж сүм дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгч орон нутгийн өмчид тусгуулах ажлыг зохион байгуулсан байна.
- Шинээр худаг гаргах гэж байгаа бол өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг нь тогтоосон акт үйлдэнэ.
- Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаарх мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ.
- Цооногийг засварласан болон өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
- Ашиглалтын цооногийн техникийн паспортыг хөтөлж сүм, дүүргийн Засагдарга, эзэшигчид хүлээлгэн өгнө.
- Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварласан, шинээр гаргасан далд ажлын тухай” Ховд аймаг, нийслэлийн ажлын хэсгийн акт №3-ыг үйлдэж, эзэмшигчид хүлээлгэн өгнө.
- Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооног бүрт суурилуулна.
- Худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүр дараах шаарлагыг хангасан байна.  
Үүнд: Гарал, үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.
- Тоног төхөөрөмжийн бүрдлийн үнийг хүснэгтээр гаргах ба нэг иж бүрдэлд: усны шахуурга, цахилгаан үүсгэгч, /хянах самбар, цахилгаан утас, холбогч, дагалдах хэрэгсэл/ зэрэг орно.

- 2.4. Усны химиин болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн байна.
- 2.5. Худгаас өдөрт дунджаар 20 тонн усны хэрэглээг хангана.
- 2.6. Шинэ худгийн цэг тогтоох хайгуулын ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх тухай албан ёсны гэрээ байгуулсан байх, хэрэв өрөмдлөгийн компани өөрсдөө энэ ажлыг гүйцэтгэдэг бол зөвшөөрөлтэй байх
- 2.7. Өрөмдлөгийн устай эсэх магадлалыг өрөмдлөгийн компани хариуцна.

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлтүүд
<b>1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох /MNS6088-2010 стандарт/</b>	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Цооногийн ашиглалтын ундрага /1,0 л/сек/-ээс дээш : цагт 2м <sup>3</sup> -6 м <sup>3</sup> ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25мм-с багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO 9001 /хүйтний улиралд тэсвэртэй/
1.6	Цооногийн хайрган шүүр: шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс томгүй байна.
1.7	Тунгаагуурын гүн 2м-ээс багагүй
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй
1.9	Усны чанарын сорилт авах, шинжилгээ хийлгэж паспортод хавсаргах
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох
1.11	Цооног өрөмдөх эхний диаметр 245,295,325мм байх ба гүнээс хамаарч цооногийн голчийг багасгах, амсар хэсэгт хамгаалалтын яндан суулгаж бэхлэх
1.12	Шүүр яндангийн хамгийн бага диаметр 127,159168мм байх
<b>2. Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих/MNS6088-2010 стандарт/</b>	
2.1	Худгийн барилга <ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээ /дотор цвэр эзлэхүүн-18м<sup>3</sup>/: 3м x 3м, Ханын өндөр шалнаас дээш тааз хүрэл 2м</li> <li>• Материал: тоосго, блок, мод</li> <li>• Ханын зузаан: 38см</li> <li>• Ханыг дотор гадна талаас шавардаж, цагаан өнгөөр будна.</li> <li>• Худгийн дээр 30см x 30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ.</li> <li>• Худгийн цонх нь 40см x 50см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана/</li> </ul>
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2 м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах
2.3	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/
2.4	Барилгын хананд 40мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
2.5	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м <sup>3</sup> -ээс багагүй багтаамжтай модон тагтай ган усан сан,
2.6	Мал уslaх онгоцны: <ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цлиндр</li> <li>• Материал: ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон</li> <li>• Худгийн байшиглаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна.</li> <li>• Онгоцны адагт үлдэгдэл ус юулэх жижиг нээлхий гаргана.</li> </ul> <p>Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ.</p>

	<ul style="list-style-type: none"> <li>Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана.</li> <li>Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг хагас цлиндр 15 мм-н диаметртэй трубагаар имжиж аюулгүй болгон засна.</li> </ul>
2.7	<p>Мал услах талбай:</p> <ul style="list-style-type: none"> <li>Хэмжээ: Онгоцны 2 талд нийт уртын дагуу 1 м-ийн урттай, 0.5 м-ийн өргөнтэй, 10см зузаантай хавтан</li> <li>Материал: 400 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийх бетоны зуурмаг 150 марк, төмөр тороор хүчитгэж өгнө.</li> <li>Услах талбай нь худгийн мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд асгарсан ус юулэгдэхэд тохиромжтой байна.</li> </ul>
<b>3. Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар</b>	
3.1	Гүний насос: ISO 9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж (туузаар ороож болохгүй) тогтооно.
3.3	Хянах самбар: Насос асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой байна.
3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO9001стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.
<b>4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх</b>	
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх гарын авлага материалаар хангах, талбайн сургалт хийх
4.3	Худгийн паспортыг сумын тамгын газарт хүлээлгэн өгөх

**ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ХУДАГ ШИНЭЭР ГАРГАХ ГАЗРЫН БАЙРШИЛ**

№	Сумын нэр	Багийн нэр	Худгийн д/д	Худгийн нэр	Худгийн төрөл	Худгийн гүн /м/	Үндрага (л/сек)
0	1	2	3	4	6	7	10
1	Дарви	Дэлгэр	1	Адуун чулуун	гө	40-50	1.0 дээш
2	Дарви	Мөрөн	2	Суурин	гө	40-50	1.0 дээш
3	Дарви	Булган	3	Харганы худаг	гө	40-50	1.0 дээш

## Тав. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тэндерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тэндериин үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт засны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | <b>1.1.</b> Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | <b>2.1.</b> Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.  |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | <b>3.1.</b> Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | <b>4.1.</b> Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br><b>4.2.</b> Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.   |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | <b>5.1.</b> Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй   |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | <b>6.1.</b> Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| <b>B. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |   |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | <b>7.1.</b> Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br><b>7.2.</b> Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | <b>8.1.</b> Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.   |

		Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
<b>9. Зөрчил, гологдол арилгах</b>	9.1.	Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
<b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b>	9.2.	Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
<b>11. Үе шатны ажлын хуваарь</b>	10.1.	Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
	<b>В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</b>	
<b>11. Үе шатны ажлын хуваарь</b>	11.1.	Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 5 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
<b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>	11.2.	Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
<b>13. Алданги</b>	12.1.	Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
	13.1.	Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
	<b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>	
<b>14. Ажил дуусгах</b>	14.1.	Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод,

<sup>1</sup> Чанарынбаталгаатхугацаагтоогоходоо Иргэнийхууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг хийвчлэн хоногт 0.05-0.10 хувиартогох бөгөөдний түншний 5-10%-иас хэтрэхгүй.

цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

- |  |   |
|--|---|
| <b>15. Хүлээж авах</b>                                   | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.  |
| <b>16. Эцсийн тооцоо</b>                                 | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.<br>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.<br>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана. |
| <b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээн ийг гарын авлага</b> | 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.<br><br>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.  |
| <b>18. Гэрээг цуцлах</b>                                 | 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.<br><br>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: <ul style="list-style-type: none"><li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 10 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li><li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 7 хоногийн дотор цуцлаагүй;</li></ul>  |

- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

#### **19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**

- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

#### **20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 1.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Нэр: <b>Бэлчээр усжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй худаг гаргах ажил</b> Дугаар: <b>ХОАДАСЗДТГ/202002011</b>
<b>ГЕН 1.1</b>	Ажил нь: <b>Бэлчээр усжуулах ажлын хүрээнд инженерийн хийцтэй худаг гаргах ажил</b> Ажлын талбай нь зураг төсөлд зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 2.1</b>	Төслийн менежер: <b>Засаг даргын орлогч Б.Энхболд</b>
<b>ГЕН 3.1</b>	Ажил эхлэх өдөр <b>2020 оны 08 дугаар сарын 29</b>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>2020 оны 09 дугаар сарын 20</b>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>730</b> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0.05 хувь</b> байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>5 хувь</b> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 20 хоногийн дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <b>2019 оны 09 дугаар сарын 20</b> -ний дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b>[мөнгөн дүн]</b> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[хувь]</b> -иар тооцно.

<sup>3</sup>

Захиалагчтэндэрийнбаримтбичгийгтараахаасөмнөгэрээнийтусгайнөхцөлийгбүрэнбөглөсөнбайна.Захиалагчийн гаргаххуваарь, тайлангтэрээнийтусгайнөхцөлдхавсаргана.

<sup>4</sup> Ажлыгхэсэгхэсэгэрдуусгах болонхэсэгбүртэлдэнгихэрэглэх болэндтусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан,

цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын  
үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]